



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

47

1989 оны 04 сарын 23

№ 115

Улаанбаатар хот

Барааны захын талаар авах
арга хэмжээний тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Барааны захын үйлчилгээний дотоод журмыг зөрчиж орлогоо нуусан, хуралдаа хийх зөвшөөрлийн хураамж, төлөөгүй иргэдэд ~~30~~ хүртэл төгрөгөөр торгь байхыг Барааны захын захиргаанд зөвшөөрсүгэй.

30 хүртэл төгрөгөөр торгь байхыг Барааны захын захиргаанд зөвшөөрсүгэй. 1989 оны 1483 А 247-д зах байх 1989 оны 1483 А 247-д зах байх

2. а. Монгол улсын хууль тогтоомж, эрхийн актаар нийтэд зарахыг хориглосон зүйлс тухайлбал: хар тамхи, мансууруулагч, тасэрч дэлбэрэх бодис, буу зэвсэг, сум галт хэрэгсэл, нулимс асгаруулагч, согтууруулагч ундаа, ам, эмийн зүйлс, ангийн ус, бугын эвэр, хүдрийн заар зэргийг зарах асуудлыг хатуу хориглохыг гадна картаар хуралдаалж байгаа бараат зах дээр бөөнөөр нь зарахыг хориглож, уг зөрчлийг илрүүлсэн тохиолдолд зохиох бараат улсын орлого болгох буюу хууль тогтоомжийн дагуу шийшварлаж байхыг Барааны төв захын дарга, шүүгч ахлах байцаагчид зөвшөөрсүгэй.

б. Хууль, тогтоомж эрхийн акт сурталчлах, сахилга даг журам сахиулах, захиргааны арга хэмжээг газар дээр нь авч байх үүрэг бүхий орон тооны шүүгч ажиллуулахыг Хотын шүүхийн дарга /н.Төрбат/, Барааны төв захын дарга /н.Мухов/-д даалгасугай.

в. Энэ тогтоолын а заалтын дагуу зөрчил илрүүлсэн захын байцаагч, орон тооны бус шалгатч, мэлээдэгч иргэдэд тухайн орлогын 10 хүртэл жувиал шагнал болгон олгож байхыг Барааны төв захын захиргаанд зөвшөөрсүгэй.

3. Зах пээр бараа зарах иргэндээ 30 төгрөгийн хураамж авч үйлчиллэг журмыг туршиж ажиллахыг Барааны төв зах /н.Мухов/, Хүнс техникийн төрөлжсөн зах /н.Даш/-д даалгасугай.

4. "Барааны төв захын цүрэм"-ийг хэвсралт ёсоор баталсугай.

5. Барааны захан хяналт шалгалтын бусад байгууллагуудаас очиж ажиллах хүмүүс нь Барааны захин захиргаанд албан ёсоор бүртгүүлж, шаардлагатай тохиоллолд бараа хураах, торгохдоо захин санхүүгийн маягт үндэслэн баримт үйлдэж байхыг холбогдох шалгагч нарт үүрэг болгосугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 4 дүгээр сарын 18-ны 113 дугаар тогтоолын 9 дүгээр зүйлийн "б" заалт, 1989 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 127 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, мөн 4 дүгээр зүйлийн "а" заалтыг тус тус хүчингүй болсонг тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР
ГААНЫ ДАРГА
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН

Хэраг эрхлэх газар *[Signature]*
Хууль зүйн газар *[Signature]*
Боловсруулсан *[Signature]*
6% М Мөнгөнцэвэр
нийлсэн *[Signature]*

48

Улаанбаатар хотын Арлын Хурлын гүйцэтгэх захиргааны 1992 оны 175-р тогтоолоор батлав.

БАРААНЫ ТӨВ ЗАХЫН ДҮРЭМ

Нэг. Нийтдэг зүйл

1. Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны харьяа барааны төв зах нь байгууллага, иргэдийн хооронд хийх хуралдааны аятай нөхцөл бүрэлдүүлд бараагаа чөлөөт үнээр борлуулах, худалдан авахад нь зуучлах, худалдааны журмыг сахихулах, зах зээл худалдааны тэтгэвэр, хураамжийн талаархи хууль тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажилладаг байгууллага мөн.

2. Зах нь дүрмэндээ заасан үйлчилгээг эрхэлж, үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцан орлогоороо зарлагаа нөхөж аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллана.

3. Төв зах нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, эрхийн актуулыг дагаж мөрдөн ажиллана.

4. Төв зах нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тамга, нэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас харагдана.

5. Төв зах нь гүйцэтгэх ажлын хэмжээ, орлогын байдлаас хамаарч орон тоо, цалингийн сангаа хамт олны хурлаас хэлэлцэж шийдвэрлэнэ.

6. Төв захыг хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас томилогдсон дарга удирдаж ажлаа зохион байгуулна. дарга зарим швардлагатай асуудлаар хамт олны хурал, хариуцлагатны хуралаар хэлэлцэж шийдвэрлэж байна.

7. Барааны төв захын дарга нь БШМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 42 дугаар зүйл болон үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх зүйн актад нийцүүлэн тушаал гаргана. Тушаалыг захын нийт бүрэлдэхүүн мөрдөж ажиллана.

8. Барааны төв зах нь төр, захиргааны хяналтын байгууллагуудтай хамтарч, хуралдааны болон нийтийн цэг журам сахиулах арга хэмжээ авна.

9. Зах дээр зэрэгийг хууль тогтоомжоор хориглосон зарим барааг эрх бүхий субъектээс хураасан болон цагцаа, шүүхийн шийдвэрээр хурааж ирүүлсэн эл зүйл өв залгамжлагчгүй хөрөнгө, эзэн нь олдобгүй газарцаж бараа заргийг хүлээн авч үнийн комиссоос үнэ тогтоосны дараа нийтэл хуралдаж болно.

Хоёр. Төв захын үүрэг, эрх

10. Барааны төв зах нь цор цурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

а/Байгууллага, иргэдийн эрхлэн хийх худалдаа, арилжааг зохион байгуулж, хөдөлмөрчлөл соёлч шуурхай үйлчилнэ.

б/Худалдан борлуулах эл бараанд чөлөөт үнээр тогтоосон таригийн дагуу нэг удаагийн хураамж авч тасалбар олгоно.

в/Мөн захял үйлчлүүлсний нэг удаагийн хураамжийг иргэдээс тогтоосон журмаар хураана.

г/Холбогдох хууль тогтоомжоор мэдээлэл хийж ажиглана.

д/Тогтоосон журмаар улсын орлого болгосон эд зүйлийг хураан авч захиргааны үнийн комиссоор худалдан үнэ тогтоосны дараа шаардлагатай бол борлуулж байх үүрэгтэй.

II. Барааны төв зах нь дор дурдсан эрх элдэнэ.

а/Худалдааны болон татвар хураамжийн журам зөрчсөн, хэв журмын зөрчил гаргасан хүмүүсийг шалгаж, тогтоосон хэмжээгээр торгох, онцгой тохиолдолд эд барааг хурааж улсын орлого болгоно.

б/Зах дээр наймаа хийх дүрэм зөрчсөн хүний биеийн байцаалт, бичиг баримтыг шалгах, хаягийг нь тогтоох, түүнтэй холбогдсон хүмүүсийг дуудан ирүүлж тодорхойлолт авах зэргээр шалгалт хийнэ.

в/Ариун цэврийн шаардлага хангаагүй хүнсний бараа, хууль тогтоомжоор зах цээр арилгахыг хориглосон барааг худаллахыг хориглоно.

г/Захны татвар хураамж төлөөгүй, орлогоо нуусан этгээцлэл ноогдуулсан торгуулийн мөнгөн төлөөсийг уг хүн тухайн үеэ төлөх бололцоогүй бол баримт бичиг буюу эд барааны зохих хэсгийг барьцаанд үлцээх гэрээг бичгээр 2 хувь үйлдээ 72 цагийн хугацаатай барьцаална.

Тогтоосон хугацаанд мөнгөө төлөөгүй бол уг эд барааг зохих хууль зүйн журмын дагуу улсын орлого болгоно.

д/Зөрчил гаргасан этгээцлийн асуудлыг захны захиргааны хэмжээнд шийдвэрлэх боломжгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

е/Захал наймаа хийх журам, сахилга бат, нийтийн хэв журмыг сахуулах ажилд төр захиргааны байгууллагын шалгагч нарыг илзвх зүтгэлтэй ажилласан тохиолдолд шагнаж урамшуулна.

з/Хамт олны нийгмийн асуудлыг нээшлүүлэх зорилгоор туслах аж ахуй хөгжүүлэх, аялал жуулчлал зохион байгуулах, ажилтан ажилчны мэтгэжид дээшлүүлэх чиглэлээр хөрөнгө мөнгө зарцуулж болно.

и/Захны талбай, ширээ сандал, саравч мухлаг зэрэг тоног төхөөрөмж, радио устель, цахилгаан ашигдлуулсны хураамж авах таригийг тогтооно.

к/Шагналын цүрмээ хамт олны хурлаараа баталж мөрдөнө.

Гурав. Хоригдох зүйл

а/Хар тамхи, мансууруулагч, тэсэрч дэлбэрэх бодис, буу завсэг, сум галт хэрэгсэл, пулимс асгаруулагч, согтууруулагч ундаа, эм эмийн

зүйлс, ангийн үс, бургин эвэр худрийн заар зэргийг зарах явдлыг хатуу чанг хориглохын гадна улсын худалдааны картын бараа бөөнөөр нь зарахыг хориглоно.

б/Барааны зах дээр нохой, муур, амьтан зарж болохгүй.

в/Бага насны хүүхдийг зах дээр дагуулах явах, тэдгээр наймаа хийлгэхийг цээрлэнэ.

г/Захын гадна талбайд худалдаа наймаа хийхийг зөвшөөрөхгүй.

д/Зах дээр архилаг сонгуурч болохгүй.

е/Захын орчинд хог, нус цэр хаях, зориулалтын бус газар бие засахыг цээрлэнэ.

ж/Захын эд хөрөнгийг зүй бус ашиглаж болохгүй.

Барааны төв захын дүрэм зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.